

УБД-ын 1991 оны 2 дугаар сарын 28-р дөх. хурал
Хурал

28



БНМАУ
УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ТОГТООЛ

1991 оны 1 сарын 28

№ 16

Улаанбаатар
ХТ

Аппаратын бүтэц, орон тоо,
цалингийн тухай

БНМАУ-ын Засгийн газрын зөвшөөрлийг үндэслэн Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ нь:

1. Аппаратын бүтцийг боловсронгуй болгох зорилгоор 1991 оны 2 дугаар сарын 1-нээр тасалбар болгон хотын гүйцэтгэх захиргааны Нийгэм, эдийн засгийн хөгжлийн газрыг татан буулгаж, Нийгэм эдийн засгийн боллогын зөвлөл, статистик мэдээллийн хэлтсийг тус тус байгуулан, Цэрэг иргэний хамгаалалтын хэлтсийг Цэрэг, иргэний хамгаалалтын газар, ~~Хүн ам зүй, хөдөлмөрийн хэлтсийг Хөдөлмөр, нийгэм хамгаалалтын хэлтэс~~ болгон өөрчлөн зохион байгуулсугай.

2. Хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны аппаратын бүтэц, орон тоо, ажилчин албан хаагчдын сарын цалинг 1 дүгээр хавсралт ёсоор баталж, энэ оны 2 дугаар сарын 1-нээс эхлэн мөрдөхөөр тогтоосугай.

3. Аппаратын газрын дарга нарын сарын цалинг 2000-2400 төгрөг, хэлтсийн дарга нарыг 1800-2000, ахлах мэргэжилтэн, ахлах зохион байгуулагч, ахлах байцаагч нарыг 1600-1900, мэргэжилтэн, байцаагч, зохион байгуулагч, тэдэнтэй ажилтгах албан тумаалтныг 1400-1800, дунд мэргэжлийн ажилтны цалинг 1100-1400 төгрөгөөр тус тус тогтоож байсугай.

4. Дор нэр дурдсан ажилтнуудыг 1991 оны 2 дугаар сарын 1-нээр тасалбар болгон үүрэгт ажлаас нь чөлөөлж өөр ажилд шилжүүлсүгэй. Үүнд:

а/М.Байгалмааг Барилга, хот тохижилт хариуцсан зохион байгуулагчийн үүрэгт ажлаас чөлөөлж, хотын Барилга, хөрөнгө оруулалтын газрын мэдэлд;

2.

б/Г.Нацагийг соёл, боловсрол, эрүүлийг хамгаалахын ажил хариуцсан зохион байгуулагчийн үүрэгт ажлаас чөлөөлж, хотын соёл, олон түмний ажлын хэлтсийн мэдэлд;

в/П.Маам, Ж.Эрдэнэцэцэг нарыг Хот байгуулалт, төлөвлөлтийн газрын мэдэлд;

г/Д.Ираг Тооцоолон бодох төвийн мэдэлд;

д/Б.Болдбаатар, Д.Бямбаа нарыг Хүн ам зүй, хөдөлмөрийн хэлтсийн байцаагчийн үүрэгт ажлаас чөлөөлж, хотын Хөдөлмөрийн захын мэдэлд.

5. Хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны удирдах бүрэлдэхүүний эрхлэн хариуцах ажил үүргийн хуваарийг 2 дугаар хавсралтаар баталсугай.

6. Газар, хэлтсийн зохион байгуулалтанд өөрчлөлт орсонтой холбогдуулж тэдгээрийн дүрэм, ажилтнууцны ажил үүргийн зааврыг энэ оны I дүгээр улиралд багтаан шинэчлэн боловсруулж мөрдүүлэхийг орлогч дарга нар, Хэрэг эрхлэх газарт даалгасугай.

7. Энэ тогтоол гарсантай холбогдуулан хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны 1990 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн 150 дугаар тогтоолын 1, 2, 5, 6, 7 дугаар заалтыг хүчингүй болсонд тооцсугай.



УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ДАРГА

ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

[Handwritten signature]
Л.ЭНЭБИШ

[Handwritten signature]
Ч.СУМААХҮҮ